



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 32 14 33, Факс: (976-11) 32 45 18,
E-mail: information@nso.mn, contact@burtgel.gov.mn,
http://ubseg.gov.mn

2016.07.28 № 1/9820
танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

Тус газар Улсын Их Хурал болон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулах, хүргүүлэх болон санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг тулган шалгах үйл ажиллагааг хуулийн хүрээнд амжилттай зохион байгууллаа.

Улсын Их Хурлын 2016 оны 06 дугаар тогтоолоор сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийг 2016 оны 10 дугаар сарын 19-ний өдөр явуулахаар товлосон.

Дээрх сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн оршин суугчдын байнга оршин суугаа газрын бүртгэлийн мэдээллийн санг үнэн бодитой болгох зорилгоор иргэдийн хаягийн бүртгэлийг цэгцлэх дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үүнд:

1. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэг хаяг дээр 10-аас дээш сонгогчтой 13794 хаягийн мэдээллийг 100 share дотоод сүлжээнээс татан авч, тухайн аймаг, дүүргийн харьяа нэг хаяг дээр 10-аас дээш сонгогч бүртгэгдсэн мэдээллийг нэг бүрчлэн шалгах, мэдээллийг хавсралт 1 хүснэгтээр ирүүлэх;

2. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжийн бүтэц өөрчлөгдсөн боловч бүртгүүлэхтэй холбоотой зардал шийдвэрлээгүйгээс байнга оршин суух газрын хаяг нь өөрчлөгдөөгүй иргэдийн судалгааг гаргах, мэдээллийг хавсралт 2 хүснэгтээр ирүүлэх

3. Хаягжуулалтын тухай хуулийн дагуу 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хаяг нь өөрчлөгдсөн иргэдийн бүртгэлийг холбогдох байгуулалтаар хамтарч яаралтай шийдвэрлэх;

4. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан болон Хүн ам өрхийн мэдээллийн сангийн 2016 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн тулгалтаар 340215 иргэний хаяг зөрүүтэй байгаа мэдээллийг 100 share дотоод сүлжээнээс татаж авч, иргэнд мэдээлж, хаягийн бүртгэлийн зөрүүг арилгах;

5. Төлбөрийн чадваргүйгээс болон бусад шалтгаанаар шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлдэггүй хаягийн зөрчилтэй иргэдийн судалгаа гаргах, хавсралт 3 хүснэгтээр ирүүлэх;

004624

5.Төлбөрийн чадваргүйгээс болон бусад шалтгаанаар шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлдэггүй хаягийн зөрчилтэй иргэдийн судалгаа гаргах, хавсралт 3 хүснэгтээр ирүүлэх;

6.Тухайн аймаг, дүүргийн харьяа хаягийн бичвэрийн мэдээллийг шалгах, засуулах шаардлагатай хаягийн мэдээллийг албан ёсоор 2016 оны 08 дугаар сарын 15-ны дотор ирүүлэх;

Байнга оршин суугаа газраасаа өөр газарт амьдарч байгаа иргэн хуульд заасан үүргээ биелүүлж, шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлээгүй бол бүртгэлийн зөрчлөө арилгах тухай мэдэгдлийг иргэнд хүргүүлж, холбогдох арга хэмжээг авч, анхаарч ажиллана уу.

Хийсэн ажлынхаа тайланг хавсралтаар хүргүүлсэн хүснэгтийн дагуу гаргаж, цахим хэлбэрээр civil_reg@burtgel.gov.mn хаягт 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Хавсралт: 3 хуудастай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН

